

12

Орон нутгийн хүнсний аюулгүй байдал

Энэ бүлэгт

Хуудас

Түүх: Тариалалтад гарсан өөрчлөлт.....	224
Орон нутгийн хүнсний аюулгүй байдал гэж юу вэ?	226
Үйл ажиллагаа: Арван үр.....	227
Хоол тэжээл ба хүнсний аюулгүй байдал.....	228
Газар тариалан өөрчлөгдөхөд идэш хоол өөрчлөгддөг	229
Түүх: Америкийн уугуул иргэдийн хоол хүнс өөрчлөгдсөнөөр эрүүл мэнд нь дордов	230
Орон нутгийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах	231
Орон нутгийн хүнсний төслүүд	232
Түүх: ДОХ-оос эцэг эхээ алдаж өнчин хоцорсон хүүхэд залууст тариалангийн талбайн сургууль нээсэн нь.....	234
Хот суурин газрын хүнсний аюулгүй байдал	235
Түүх: Ардын хүнсний дэлгүүр	235
Хүнсний аюулгүй байдлыг хот газарт төлөвшүүлэхэд засгийн газрын тусламж хэрэгтэй	236
Хотуудын тогтвортой хүнсний бодлого	236
Өлсгөлөнгийн нийгмийн болон улс төрийн шалтгаан	237
Корпорациудын хяналт хүнсний аюулгүй байдалд аюул учруулдаг	237
Түүх: Хуурайшилтай тэмцэхийн тулд алга болсон үрийг сэргээсэн нь	238
Хоол хүнсний бие даасан байдал нь хүний эрх юм	241
Түүх: ВИАКАМПАСИНА хоол хүнсэн дээр ард түмний хяналт тогтоохыг дэмжив	241



Эрүүл байхын тулд хүмүүс тэжээллэг хоол унд идэх хэрэгтэй. Хэрэв өөрсдөдөө болон гэр бүлийнхэндээ хангалттай хэмжээний хоол унд тарьж, ургуулж, өсгөж, худалдан авч, худалдан борлуулж чадахгүй бол бид өлсгөлөн, тэжээлийн дутагдал болон бусад эрүүл мэндийн асуудалтай тулгардаг.

Хоол хүнсний аюулгүй байдал гэдэг нь бүтэн жилийн турш хүн бүхэн эрүүл идэвхитэй ажиллаж амьдрах хэмжээний аюулгүй тэжээллэг хоол ундтай байна гэсэн үг юм. Түүнчлэн хүнсийг эрүүл орчинд тарьж ургуулан, зөв хадгалж, зарж борлуулах, орон нутгийн хэмжээнд хүнсээ өөрөө хангах, орон нутгийн хэмжээнд байгаа хүн бүхэнд хоол хүнс хүрэлцээтэй байлгах гэсэн үг.

Өлсгөлөн олон шалтгаантай. Зарим хүмүүс өлсгөлөнгийн гол шалтгаан нь үржил шимгүй муу хөрс, цаг агаарын өөрчлөлт, усгүйдэл гэж үздэг. Ийм шалтгаанаар үүссэн өлсгөлөнг тогтвортой хөдөө аж ахуй /15-р бүлгээс үзнэ үү/ хөгжүүлэх замаар буюу газар усны асуудлыг шийдэх замаар /6, 9, 11-р бүлгийг үз/ тус тус шийдэж болно.

Өлсгөлөнгийн өөр нэгэн шалтгаан нь улс төрөөс хамаардаг. Жишээлбэл, хүнсний бүтээгдэхүүний үнэ шударга бусаар тогтоогдох, тариа тарих газар байхгүй байх, зах зээлийг цөөхөн хэдэн компани эзлэх зэрэг улс төрийн шалтгаан бий. Ийм шалтгаантай өлсгөлөнг орон нутгийн зохион байгуулалттай үйл ажиллагаагаар зохицуулж болно.

Хоол хүнс үйлдвэрлэхийн тулд бидэнд ус, газар, багаж, үр болон газар тариаланг хэрхэн өөрчлөх талаарх мэдлэг хэрэгтэй байдаг. Хүн бүхэнд хоол хүнсийг хүргэхийн тулд шударга хуваарилалт, хүнсний бүтээгдэхүүний шударга боломжийн үнэ, орон нутгийн захууд болон хүнсний аюулгүй байдал шаардлагатай байдаг. Эдгээр үр дүнд хүрэхийн тулд бид тогтвортой ажиллах шаардлагатай болно. Зөвхөн эрүүл орчин, нийгмийн шударга ёсны төлөө ажиллаж байж л хүнсний аюулгүй байдлыг хүн бүхэнд баталгаажуулж өгнө.

Тариалалтад гарсан өөрчлөлт

Камбожи улсын Фрэйвинг гэдэг газарт хүмүүс хэдэн мянган жилийн турш хангалттай идэж хүрэлцэхүйц цагаан будаа тариалж чаддаг байжээ. Тэд зэрлэг өвс, ногоо, загас, хорхой, могой болон бусад амьтдыг цагаан будаатайгаа хольж иддэг байжээ. Мөн жимс, самар, ойд ургадаг ургамлын үндэс, ан амьтны мах тасардаггүй байлаа. Энэхүү хоолны орц нь бүтэн жилийн туршид хүмүүст эрүүл өсөж торних бололцоог олгодог байв. Зөвхөн дайны болон үерийн үед л тэд өлсдөг байжээ.

Дөчин жилийн өмнө засгийн газар нь газар тариалангийн шинэ аргыг дэмжиж эхэлжээ. Ингэснээр тэд экспортод гаргадаг цагаан будаа мэтийн хэдхэн цөөхөн тооны үр тариаг эрс нэмэгдүүлжээ. Энэ шинэ арга нь дэлхий нийтийн хэмжээнд хөдөө аж ахуйд гарсан өөрчлөлтийн нэг хэсэг байсан бөгөөд “Ногоон хувьсгал” хэмээн нэрлэгддэг байжээ.

Ногоон хувьсгалын үеэр химийн хорт бодис бордоогоор дэмжиж цагаан будааг уламжлалт аргаас өөрөөр тарих болжээ. Энэ арга нь уламжлалт усалгааны системийг эвдэж, том том усны сүлжээгээр усалгаа хийж, том машинуудаар тариалалт тарьж ургацаа хураадаг байжээ.

Анх ийм тариалалтыг эхэлж байхад Фрэйвингийн хүмүүс маш их хэмжээний цагаан будаа тариалж чаджээ. Тэд их мөнгө олж, байшин барьж, радио телевиз авч эхлэв. Тосгоныхон амьтныхаа ялгадсыг хэрэглэхээ больж, цагаан будаагаа хуучин будаатайгаа хольж хэрэглэхээ больж, уламжлалт бүх аргаа мартжээ. Шинэ арга нь ганц том талбайд ганц төрлийн ургамал тариалахад тохиромжтой учраас тэдний тариалалтад цагаан будаа ихээр нэмэгджээ.

Харин цаг хугацаа өнгөрөхөд хүмүүсийн иддэг хоол унд, газар их өөрчлөгдсөн гэдгийг тэд анзаарав. Өмнө нь иддэг байсан зэрлэг ургамлыг химийн бодисууд устгаж, загас болон могой, зэрлэг амьтад цөөрчээ. Жилээс жилд тэд химийн бодист хамаг мөнгөө зарцуулан будаанаас өөр идэх зүйлгүй болсон байна. Удсан ч үгүй газар эрүүл байж чадахаа больж үржил шимгүй болж, цагаан будааны ургац буурч эхэлжээ.

Өлсгөлөн ядуурал нэмэгдэж эхэлмэгц тосгоныхон ярилцаад хуучныхаа аргаар холимог тариалалт хийж, үрээ сольж ашиглан жилийн турш ургац гаргаж чаддаг байгалийн бордоогоо хэрэглэх нь зөв юм байна гэж шийджээ. Тэд уламжлалт аргад байгаа олон давуу талуудыг санагалзаж буцаад хуучин аргаар тариалалт хийхээр шийдэв. Тэд бас хуучин аргаа сэргээхдээ хэд хэдэн талбай дээр ойр ойрхон өөр зүйл тариалахаар шийджээ.



Ингэж хуучин аргаараа тариалахад хөрсийг сэргэтэл хэдэн жил өлсгөлөнд нэрвэгдэв. Гэвч үргэлжлүүлэн тордсоор Фрэйвинг тосгон хэвийн байдалд оржээ. Тэд их хэмжээгээр зарах цагаан будаагүй болсон ч өөрсдөө идэх олон төрлийн ногоотой болж чадсан байна. Хотын уугуул иргэн Рэйвив хэлэхдээ бид хоол тэжээлээ өвөг дээдсийнхээ замаар ургуулсан учир тэд тэнгэрээс инээж ургамлууд ч аз жаргалтай байна гэв.

Орон нутгийн хүнсний аюулгүй байдал гэж юу вэ?

Хангалттай хэмжээний эрүүл хоол хүнс олоход ямар асуудал тулгардагийг мэдэхийн тулд хүнсний аюулгүй байдлыг бий болгодог олон хүчин зүйлийг хамтад нь харах хэрэгтэй.

Хоол хүнсний үйлдвэрлэл: газартай байх эрх үүрэг, ус, тариалалтын талаарх мэдлэг туршлага, зарж борлуулахад зориулсан хүнс болон идэхэд зориулсан хүнсний зөв харьцааг тогтоох.

Мөнгө, хадгаламж ба зээл: хүмүүс хүнснийхээ хэрэгцээний ядаж заримыг хангахын тулд мөнгөтэй байх хэрэгтэй. Хүнс хоол үйлдвэрлэгчид үр авах зээлтэй байх хэрэгтэй. Мөн ургац алдсан жилүүдэд хэрэглэх мөнгө, зээл, хадгаламжтай байх хэрэгтэй байдаг.

Сайн эрүүл мэнд: хүмүүс хоол унднаас тэжээлийг нь ялгаж шингээж авахын тулд эрүүл байх хэрэгтэй. Хүмүүс бохир уснаас болон удаан хугацааны өвчлөл хумхаа буюу ДОХ зэргээс болж орон нутгийнхандаа зориулж эрүүл хоол үйлдвэрлэх чадваргүй болдог.

Хүнсний тээвэрлэлт ба хуваарилалт

Хүнс хоолыг зах зээл рүү хүргэх болон хүмүүсийг хүнсээ авах гэж зах зээл рүү явахад нь хүргэж өгөх унаа зам тээврийн асуудал юм.

Хүнсний хадгалалт: орон нутгийнхан ихэвчлэн хоол хүнсийг 3-4 сар хадгалж, хуурай юм уу борооны улирлыг өнгөрөөх, эсвэл өвлийн улирлыг өнгөрөөх хэрэгтэй болдог. Хоол хүнсний хадгалалт нь хоолыг хортон шавжнаас бас хамгаалдаг. Таны хоол хүнсний талыг нь хулгана харх идчихвэл та өлсөнө.

Шавжны хор, хортой химийн бодис, нянтай буюу генетик инженерийн аргаар өөрчилсөн хоол хүнс элбэг дэлбэг байж болох боловч аюулгүй эрүүл хоол хүнс байж чаддаггүй. Мөн эрүүл гал тогооны байр, хоол хүнсийг буцалгаж бэлтгэх хангалттай цаг хугацаа байхгүй бол хүмүүс ихэвчлэн бэлэн хоол идэж үүгээр дамжуулан эрүүл мэндийн асуудалтай тулгардаг.

Арван үр

Энэхүү дасгал нь хүмүүст орон нутгийнхаа хүнсний аюулгүй байдлын чухал асуудлуудыг ойлгож таних, ингэснээр орон нутагтаа хүнсний аюулгүй байдлаа сайжруулах шийдвэр гаргахад нь тусална.

Хугацаа: 2 цаг.

Материал: бүлэг бүрт 10 ширхэг үр, өнгөт үзэг харандаа, маркер болон том цагаан цаас шаардагдана.

- Бүлгийг 8-10 хүнд хуваана. Бүлэг бүр хүнсний аюулгүй байдлыг бий болгодог хүнсний үйлдвэрлэл, хадгалалт, зах зээл дээрх эрүүл хүнс, хүнс хоол хадгалах сайн газар зэргийг ярилцана. Тариа тарьж мал малладаг, загас агнуур хийдэг орон нутгийн иргэд хотын иргэдээс өөр хүнсний асуудал ярилцана. Таны амьдардаг орчинд хүнсний аюулгүй байдлын ямар асуудал байгааг ярилц. Том цаасан дээр хүнсний аюулгүй байдлын янз бүрийн хэсгүүдийг зурах, эсвэл бичих замаар үзүүл.
- Бүлэг бүрт арван үр өг. Ингээд хүнсний аюулгүй байдлын аль хэсэгт нь хамгийн их асуудалтай байгаа вэ гэж асуу. Хамгийн их асуудалтай байгаа газраа олон үр тарих хэрэгтэй. Жишээлбэл: хоол хүнсний дутагдал байгаагаас айлууд өлсөж байна уу? Эсвэл хоолыг зах зээл дээр хүргэж өгөх унаа байхгүйгээс зах зээл дээр хоолгүй байна уу? Эсвэл муу хүнс хортон шавжнаас болж хүнсгүй байна уу? Эдгээр асуултууд хүнсний салбарын аль хэсэгт хамгийн сул дорой байгааг тодруулахад тусална. Орон нутаг бүрт асуудлууд нь өөр өөрөөр тулгарч байгаа. Иймээс хүн бүхний асуудлыг сонсож оролцуул.
- Бүлэг бүр өөрсдийн хүнсний аюулгүй байдлын хамгийн яаралтай асуудлыг тодорхойлсны дараа орон нутгийн ямар нөөц үүнд тусалж чадахыг хэлэлц. Хэрэв хүнсний үйлдвэрлэл хамгийн том асуудал байгаа бол гэрийн ногооны талбай, газар тариалангийн туршлагаасаа хуваалцах хүмүүс байгаа юу? Хэрэв хүнсний хадгалалт нь хамгийн том асуудал болчихоод байгаа бол түүнийг сайжруулах арга бий юу? Хэрэв зах зээл тэр хавьд байхгүй бол орон нутгийн хүнсний захыг байгуулж болох уу? Эсвэл орон нутагт хүнс зөөж авчрах ачааны машины мөнгийг дундаасаа төлж байх уу гэх зэргээр санаанууд гаргуулж цуглуул. Хүн бүхний санаа хэрэгтэй.
- Байж болох шийдлүүдийг хэлэлцсэний дараа бүлэг бүр дахин том цаас авч хамгийн практикт ойрхон шийдвэрүүдийг бич. Үүнийхээ дараа тэр шийдвэрүүд болгоныхоо ард арван үрээ тавьж үз. Шийдвэрлэхэд хамгийн ойр, практик ач холбогдолтой шийдвэрүүд аль нь болохыг тодорхойл



- 4 Бүлэг бүр асуудал болон шийдэл дээрээ тохиролцсоны дараа ангиараа нийлж цугларна. Мөн л арван үрийг ашиглан, эсвэл гараа өргөх замаар хамгийн их олон хүнд таалагдсан нэгээс хоёр шийдлийг сонго. Энэ хоёр шийдвэрийг практикт яаж хэрэгжүүлэх талаар ярилц. Үүнийг хэнийг оролцуулан хийх вэ? Орон нутгаас нөөц гаргаж чадах уу? Хэзээ ажиллаж эхлэх вэ? Жишээлбэл, хоёр жилийн дараа эхэлье гэх төсөл өнөөдрийн хүмүүсийг өлсгөлөнгөөс аварч чадахгүй. Мөн богино хугацааны зорилт тавьж болно. Жишээлбэл, орон нутгийн хүмүүсийн нөөцийг сар бүр цуглуулж гурван сарын дотор орон нутгийн дэлгүүртэй болж болно. Мөн орон нутгийн хүмүүсийн хүчийг дайчлан тариалалтын улирал эхлэхээс өмнө газар чөлөөлж тариалтад бэлтгэж болно.

Хоол тэжээл ба хүнсний аюулгүй байдал

Хүмүүс өвчтэй юм уу, хоол хүнсний дутагдалтай үедээ хоол хүнс үйлдвэрлэх, ус зөөх, гэр цэвэрлэх, орчны ариун цэврийг сайжруулах чадвар идэвх муутай болдог. Харин эрүүл, хүнсний үнэ боломжийн байвал, хүнсийг тогтвортой арга замаар үйлдвэрлэдэг бол, мөн хоол хүнс орон нутгийн зах дэлгүүрүүдээр хангалттай байдаг бол хүмүүс олон төрлийн эрүүл идэш тэжээлтэй байдаг. Хоол унд сайтар идэхгүй байх нь биеийг сулруулж доорх зүйлсийн шалтгааныг бий болгодог:

- Хурцаар гүйлгэж туулгах, **ялангуяа хүүхэд**. Хүүхдийн улаан бурхан өвчин хүндэрч аюултай болох.
- Жирэмслэлт болон төрөлт аюултай болж хүүхэд хэтэрхий жижиг, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй, оюун санааны хөгжил дорой төрнө.
- Цус багадалт, ялангуяа эмэгтэйчүүдийнх нэмэгддэг.
- Сүрьеэ өвчин нэмэгдэж хурдан хугацаанд хүндэрдэг.
- Биед орсон сахарыг зөв хэрэглэх чадваргүй болгодог цусны диабет өвчин нэмэгдэнэ.
- Ханиад хүрэх нь элбэг болж, ханиад хүрсэн үедээ ихэвчлэн хүндэрч хатгаа бронхит болдог.
- ДОХ-той хүмүүс илүү хурдан өвчилж хүндэрдэг ба тэдэнд эм үйлчлэхгүй болдог. Мөн химийн бодисоос тархсан хоолойны астма, хүнд металлын хордлого, силикатын гаралтай уушигны архаг үрэвсэл зэрэг өвчнүүд элбэгшиж хүндэрдэг.

Хүнс тэжээлийн дутагдалд орсон хүүхдүүд удаан өсч, сургуульд муу суралцаж, зарим үед сургуульд явах чадваргүй сул дорой болдог. Хоол тэжээлийн дутагдал нь ихэвчлэн жижиг хүүхдүүдэд тусдаг өвчин ба яаралтай эмчлэх хэрэгтэй. Энэ өвчний тухай илүү судалж хүүхдийг эмчилье гэвэл эмнэлгийн номноос нэмж үзэж болно.



Нойтон тэжээлийн дутагдал:
Энэ хүүхэд яс арьс болтлоо туржээ.



Хуурай тэжээлийн дутагдал
Энэ хүүхэд яс, арьс, ус гурав л болжээ.

Жанк хоол нь эрүүл биш хүнс юм

Хүмүүс хоол ундаа тариалах газаргүй олон хүн амьдардаг хотод оршин сууж байвал зах дээрээс эрүүл хүнс худалдаж авч чадалгүй хотын янз бүрийн бизнесийнхний борлуулдаг жанк буюу “хогийн” хэмээх хочтой уламжлалт биш хоолуудыг авч иддэг. Энэ хоолуудад ихэвчлэн хоолны тэжээллэг хэсгийг нь алга болгож химийн болон тосонд шарах аргаар амт оруулж их хэмжээний давс, сахар хольсон байдаг.

Бага хэмжээгээр идэхэд ийм хоол хоргүй байж болно. Харин үүнийг өдөр тутмын хоолны оронд олон удаа хэрэглэвэл бидний биед шаардлагатай тэжээлийг дутагдуулж эхэлнэ. Хүмүүс жанк хоолыг их хэмжээгээр идсэнээс болж хэтэрхий их таргалж, цусны даралт ихсэх, цус харвах, цөсний чулуутай болох, диабет өвчин тусах, мөн зарим төрлийн хорт хавдартай болох зэргээр эрүүл мэндээ хордуулдаг. Ийм учраас хоол ундны дутагдалтай хэрнээ хэт их таргалдаг үзэгдэл гарч ирдэг.



Газар тариалан өөрчлөгдөхөд идэш хоол өөрчлөгддөг

Дэлхийн өнцөг булан бүрт газар тариаланчид газраасаа зайлуулагдаж байна. Орон нутгийн иргэдэд зориулан хоол хүнс ургуулдаг газрууд одоо экспортод зориулан их хэмжээний хоол ургуулах болжээ. Корпорациуд газар, үр, зах зээл, хоолны хангамжийн сүлжээг улам бүр гартаа оруулж хянах болсноос зөвхөн тариаланчдад хохирол учруулаад зогсохгүй хүмүүс бидэнд нийтэд нь хохирол учруулдаг юм. Эрүүл хоол хүнсийг олоход улам л хэцүү болж байна. Том хотуудад жанк хүнс, архи дарс, хууль бус хар тамхи худалдан авах нь шинэ дарс, шинэ ногоо худалдан авахаас хамаагүй хялбар байна. Энэ нь бидний хоол хүнсний орцод том өөрчлөлт оруулж байна.

Бидний эмээ өвөө нар хоолоо хийхдээ шинэ ногоогоор амталдаг байсан бол одоогийн хүмүүс хэтэрхий их амталсан хоол, амталгааны материал, химийн бодис агуулсан тэжээллэг багатай хольцууд, хоол өнгө амт оруулагч янз бүрийн хатаасан бодисууд, сахар, давс, өөх тосыг их хэмжээгээр хэрэглэдэг болжээ. Хэдийгээр бид хуучнаасаа хамаагүй их хоол иддэг болсон боловч хуучны хоол унднаас тэжээллэг чанараараа муу байдаг болов.

Америкийн уугуул иргэдийн хоол хүнс өөрчлөгдсөнөөр эрүүл мэнд нь дордов

Хэдхэн үеийнхний өмнө Америкийн уугуул иргэд эрүүл хоол хүнстэй байж, зэрлэг ургамал амьтан олноор хэрэглэдэг байжээ. Мах ногоо, жимс ховор үед тэд амь зогоох хүнс буюу үндэс үр, модны холтос, жижиг амьтад зэргээр хооллодог байлаа. Зуун жилийн өмнөөс эхлэн Америкийн засгийн газар нутгийн уугуул иргэдийг дархан цаазтай газарт амьдруулахыг зөвшөөрч, тэдэнд ан агнаж загас барихыг нь хорьсон юм. Индиануудын идэж өссөн хоол хүнсээр нь хангахын оронд Америк тэднийг цагаан гурил, сахар, хашин тосоор хангажээ. Өнөөдөр уугуул америкчуудаас олон хүн засгийн газрын өгсөн хоол ундыг идсээр байна.

Дархан цаазтай олон газарт хэрэглэж болох ганц хүнс нь шарсан төмс зэрэг жанк хоол юм. Засгийн газраас хоол хүнс авдаггүй хэсэг нь цөөхөн төрлийн хоол идэж байна. Чанар багатай муу хоол идэхээс өөр аргагүй болсон учраас америкийн уугуул иргэдийн ихэнх нь жингийн илүүдэл болон бусад өвчлөлтэй болжээ. Америкийн уугуул иргэдийн дунд сахарын диабетээр нас барах нь үхлийн тэргүүлэх шалтгаан болсон байна.

Энэ асуудлаас болж зарим америкийн уугуул иргэд өөрийн соёлоо сэргээж, уламжлалт хоол хүнсийг буцаан авчрах замаар хүмүүсийнхээ эрүүл мэндийг сайжруулах ажил хийжээ. Тэд вандуй, эрдэнэ шиш, хулуу тарьж, зэрлэг цагаан будаа түүж, одос үхэр тэжээж үржүүлэн загас агнаж эхэлжээ. Лакато хэмээх омгийнхны эрүүл мэндийн ажилтан Ричард Төмөр Үүл хэлэхдээ “Соёлын уламжлалт амьдралын хэв маяг, уламжлалт хооллолтыг эвдэж өөрчилсөн нь сахарын диабетийг үүсгэсэн” гээд эцэг өвгөдийнхөө иддэг байсан зүйлийг идэж, амьдрах аргыг нь үргэлжлүүлснээр өвчнийг дахин алга болгож байна гэж дүгнэсэн юм.



Олон янзын ногоог нэг дор тариалах зэрэг газар тариалангийн уламжлалт аргууд нь эрүүл мэндийг баталгаажуулж, газрыг хойч үеийнхэндээ хадгалж үлдээж чадна.

Орон нутгийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах

Засгийн газар бүр хүмүүсээ өлсгөлөн байлгахгүйн тулд арга хэмжээ авдаг байх ёстой. Засгийн газраас хүмүүстэй гэр бүлийн ногооны талбайг ашиглахад нь дэмжиж, газар усыг хордохоос нь хамгаалж, тариаланчдад боломжийн зээл олгож, тариаланчдыг асуудлаа шийдвэрлэхэд нь тусалдаг байх ёстой.

Зарим засгийн газрууд хүнсний аюулгүй байдлыг сайжруулахын тулд тариаланчдад татаас олгодог. Татаасуудыг үнийн зөрүү олгох, эсвэл зах зээл дээр үнээ өндөр тогтооход нь туслах, мөн худалдан авагчдыг хүнс худалдан авахад нь үнийг бууруулах арга хэмжээ авч үнийн зөрүүг төлөх зэргээр олгох шийдэл гаргадаг. Гэхдээ засгийн газрын дэмжлэгийн мөнгийг хүнс хоол үйлдвэрлэдэг, ялангуяа эрүүл биш хүнсийг хийдэг корпорациуд авах нь элбэг байдаг. Ялангуяа засгийн газар авлигын маягаар зарцуулж хүнсний том корпорациудад дарамтлуулбал улам илүү өлсгөлөн, муу хоол үүсдэг.

Гэвч засгийн газрын дэмжлэг байсан байгаагүй хүмүүс өөрсдийн хүнсний аюулгүй байдлыг хамгаалах олон арга олж чаддаг. Жижиг ногооны талбай байгуулахаас эхлээд хөдөөний зах дээр хоол хүнсээ зарах, зохион байгуулалтад орох хүртэл хүнсний аюулгүй байдлын талаар гаргасан өөрчлөлт шинэчлэлт нь хүмүүст улам ихийг хийх боломжийг өгнө.



Орон нутгийн хоол нь эрүүл шинэ байдаг ба орон нутгийн соёл, эрүүл мэндийг дэмжиж өгдөг.

Орон нутгийн хүнсний төслүүд

Орон нутагтаа хоол хүнсээ үйлдвэрлэж, орон нутагтаа хуваарилж байгаа үед хүнсний аюулгүй байдал хамгийн сайн хангагдана. Орон нутагт ургасан хүнс шинэ учраас илүү тэжээллэг байдаг. Мөн энэ нь орон нутгийн эдийн засгийг тэтгэж орон нутагт байгаа фермер бизнесменүүдэд өсөж дэвжих боломж өгнө. Түүнчлэн орон нутгийнхныг илүү хамтач, илүү таатай хөршүүд болгодог. Орон нутгууд нь ихэвчлэн жижиг газартай, жижиг хүнсний захтай, ядуу байдаг учир өөрсдийн хоол ундны үйлдвэрлэл, түгээлт нь тэднийг хүчтэй болгох чухал ач холбогдолтой.



Орон нутгийн хүнсний хөтөлбөрүүд хөдөө аж ахуйн соёлыг хадгалж, уламжлан үлдээх ач холбогдолтой.

Орон нутагтаа илүү их хоол хүнс үйлдвэрлэх арга замууд

Доорх төслүүдийн ихэнх нь маш бага газар бага мөнгө зарцуулан орон нутагтаа шинэ хоол хүнстэй болоход тусална.

- **Гэр бүлийн ногооны талбайн тариалалт:** энэ нь гэр бүлийн хоол хүнсэнд эрүүл ногоо, эрүүл жимсийг нэмж баяжуулж өгнө.
- **Сургуулийн ногооны талбайн тариалалт:** энэ нь сургуулийн хүүхдэд тэжээллэг шинэ хүнсний ногоог хангана. Мөн хүүхдэд ногоо тарих аргыг зааж энэхүү чухал мэдлэгийг үе дамжуулан сургана.
- **Орон нутгийн нөхөрлөлийн ногооны талбай:** орон нутгийн нөхөрлөлийн гишүүд хамтарч талбай аван ногоо тарьж болдог. Энэ нь хүн бүхэнд газрыг хуваан авах бололцоогүй газруудад хүмүүст хүнс хоолны үйлдвэрлэл, туршлага солилцох, шинэ бизнес эхлэх, ресторан болон зам барихад тусалдаг. Тэр ч байтугай маш жижигхэн хэмжээний ногооны талбай ч хүнсний аюулгүй байдалд том тус болж чадна.
- **Орон нутгийн дэмжлэгтэй хөдөө аж ахуй:** орон нутгийн дэмжлэгтэй хөдөө аж ахуй гэдэг нь тариаланчид газар дээрээсээ хэрэглэгчдэд шууд хоол хүнсийг зарах төсөл юм. Жишээлбэл, хүмүүс газар дээр тариа ногоог тарихаас өмнө тариаланчид мөнгөө төлөөд хариуд нь ургацын улирлын туршид шинэ жимс, шинэ ногоо болон бусад хоол хүнсийг долоо хоног тутамд авч хэрэглэнэ. Ийм хөрөнгө оруулалт хийснээр хэрэглэгч нар тариаланчдад газар дээрээ амьдрахад нь тусалж, хариуд нь хоолыг хамгийн тэжээллэг байх үед нь авч хэрэглэж чадна.
- **Үр хадгалах хөтөлбөр:** энэ нь уламжлалт үрийн нөөцийг хангалттай байлгахад тусална. Хангалттай хэмжээний олон төрлийн үртэй байх нь тогтвортой хөдөө аж ахуйг хэрэглэх гол үндэс болно. /15-р бүлгийг үз/

Эрүүл хүнсийг шударга үнээр зах зээл дээр хангалттай байлгах

Дэлхий дээр хүн бүхэнд элбэг дэлбэг хүрэлцээд хангалттай хэмжээгээр илүү гарахуйц их хүнс хоол үйлдвэрлэгдэж байдаг. Гэвч хүмүүс өлсгөлөнд нэрвэгдсээр байна. Энэ нь ихэвчлэн хүнс хоолны бүтээгдэхүүн ядуу хүмүүст худалдан авахын аргагүй өндөр үнэтэй байдагтай холбоотой. Хүнсний бүтээгдэхүүний худалдан авагч болон худалдагч нарын аль алинд нь тохирохуйц шударга үнэтэй байлгахад засгийн газрын дэмжлэг чухал. Орон нутгийн хэмжээнд эрүүл хүнсийг шударга үнээр хангах хэд хэдэн арга замууд бий үүнд:

- **Хөдөөний зах:** /фермерчдийн зах/ энэ зах нь тээврийн хөлс болон хот хөдөөгийн хооронд ажилладаг зуучлагч нарын төлбөрийг хэмнэж орон нутгийн иргэд орон нутгийн хоол хүнсийг бага үнээр худалдан авах боломж олгоно. Хөдөөгийн зах нь хэрэглэгч нар өөрсдөө ирж малчид тариаланчидтай уулзаж ярилцан хоол хүнс нь яаж ургаж байгааг асууж сурвалжлах боломж олгоно. Энэ нь хөдөөний малчид тариачдад хэрэглэгчдээ мэдэхэд нь тусалж, хэрэглэгчдийнхээ хэрэгцээнд тохирсон хоол хүнсийг бэлтгэж ургуулахад нь шинэ санаа өгнө.
- **Хүнсний нөхөрлөлүүд:** энэ бол хоол хүнс худалдаж авдаг ажилчид болон энгийн хүмүүсийн хамтын өмчийн зах юм. Хүнсний нөхөрлөлийн гишүүд нь хүнсний захаас авч байгаа хоол хүнснийхээ зарим хэсгийг төлөхийн тулд зах дээр ажилладаг. Хүнсний нөхөрлөлийн гишүүд ихэвчлэн орон нутгийн бүтээгдэхүүнийг зарж, орон нутгийн бүтээгдэхүүнийг худалдан авах бодлого баримталдаг.
- **Тариаланчдын нөхөрлөл:** энэ нь тариаланчдад ургуулсан бүтээгдэхүүндээ сайн үнэ тогтоолгохын зэрэгцээ хэрэглэгч нартаа дарамт багатайгаар нэгдсэн үнэ тогтооход нь тусалдаг. /319-р хуудсыг үз/



Аюулгүй хүнсний агуулах

Аюулгүй хүнсний агуулах нь хүнс хоол ургуулахын нэгэн адил амин чухал хэрэгцээтэй зүйл юм. Хуурайшил, шуурга, үер, хортон шавжны нүүдэл, өвчин гарах зэрэг гэнэтийн аюулын үед орон нутгийн иргэдэд хангалттай хэмжээний хүнс хоол үлдээх, хангалттай хэмжээний орлого олох эх үүсвэртэй үлдээх нь хүнсний агуулахын гол зорилго юм. Орон нутгийн хүнсний агуулахын хөтөлбөр нь энэ асуудлыг даван туулахад тусална. Хүнс хоол хадгалах, түүнийг хортон шавжаас хамгаалах аргыг 311-р хуудаснаас үз. Гэрт байгаа хоол хүнс муудахаас хамгаалах аргуудыг 381-р хуудаснаас үз.

Жишээлбэл, Номхон далайн Тимоти арал дээр далайн шуурга ургацыг ойр ойрхон устгадаг. Хоол хүнсний аюулгүй байдлаа хамгаалахын тулд орон нутгийн иргэд нийтийн эзэмшлийн том нүх ухаж түүндээ исгэлэн кассава, боловсорч дуусаагүй үрнүүд, банан жимс, талхан жимс зэрэг жимснүүдийг хадгалдаг. Хүн бүхэн хүнсний нүх ухахад гар бие оролцдог бөгөөд хүнсний агуулахыг дүүргэхэд өөрийн хувь нэмрийг оруулдаг. Ургац алдаж өлсгөлөн нэрвэх үед нөөцөнд байгаа хүнсийг тэд ижил тэгш хувааж хэрэглэнэ.

Хүнсний банк

Хүнсний банк гэдэг нь хоол хүнсийг цуглуулж аваад дараа нь хэрэгцээтэй хүмүүст нь өгдөг үйлчилгээ юм. Хүнсний банкны үйлчилгээ өлсгөлөнгийн үед тусалдаг. Харин өдөр тутмын юм уу удаан хугацааны үйлчилгээг хүнсний банкнаас хангах нь төвөгтэй бөгөөд хүмүүсийг хүнсний банкнаас хэт хараат болгох нь муу зуршил болдог.

Харин орон нутгаараа өлсгөлөнд ороход хүнсний банкаар дамжуулан гадаадын орнууд хоол хүнсийг шилжүүлж өгдөг. Хүнсний банк нь гэнэтийн үед тус болох богино хугацааны шийдэл ба хүнсний аюулгүй байдлыг хамгаалж чаддаггүй.

ДОХ-оос эцэг эхээ алдаж өнчин хоцорсон хүүхэд залууст тариалангийн талбайн сургууль нээсэн нь

Африк тив даяар, түүний дотор Мозамбик улсад эцэг эхчүүд нь ДОХ-ын халдвартайгаас эрт нас барснаас болж мянга мянган хүүхдүүд өнчин, өлсгөлөн үлдэж байна. Тэнд байгаа хүүхдүүд тэжээлийн дутагдал, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй байна. Эцэг эх нь нас барсны дараа олон хүүхдүүд өрхийн тэргүүн болцгоож, хоол хүнс мөнгө олох ажилд гарчээ. Энэ нь ажлын байр байхгүй хөдөө орон нутагт хамгийн хэцүү ажил юм. Хэдийгээр хүүхдүүд тариачин айлын хүүхдүүд боловч тэдний эцэг эх нь газар тариалангийнхаа ур чадварыг хүүхдүүдээ зааж өгч амжилгүй нас барцгаажээ. НҮБ-ын дэлхийн хүнсний хөтөлбөр болон Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагууд хамтран ийм хүүхдүүдэд зориулж залуу фермерүүдийн талбайн дадлага сургууль хэмээх сургуулийг байгуулж өгчээ. Ийм сургуульд 12-18 настай хүүхдүүд ажиллаж газар тариалан тарих, хоол тэжээл бэлдэх, эмийн ургамал тарьж амьдралын дадлага туршлага олж авахад суралцаж байна.

Залуучууд уламжлалт болон орчин үеийн газар тариалангийн аргуудыг судалж, үүний дотор тариалангийн талбайг бэлтгэх, үр цацах, шилжүүлэн суулгах, хогийн ургамлыг цэвэрлэх, усжуулах, хортон шавжтай тэмцэх, байгалийн нөөц бололцоог ашиглаж хамгаалах, хүнсний ургацыг хураан авах, боловсруулах, хүнс хоол хадгалах болон маркетингийн урлагт суралцаж байна. Театрчилсан тоглолт болон ярилцлагын аргаар тэд амьдралын урлагт суралцаж, үүнээс ДОХ, хумхаа өвчин, жендерийн тэгш эрх, хүүхдийн эрхийн талаар мэдээлэл авна.

Мозамбикт залуу тариаланчдын дадлагын сургалт 28 байгаа бөгөөд Намиб, Замби, Танзани улсуудад өөр олон ийм сургууль бий. Мянга мянган өнчин хүүхдүүдийг хөдөө аж ахуйн тариаланчийн чиглэлээр сургаж байна. Сургууль төгссөн хүүхдүүд сургууль дээр олсон ургацын мөнгөөр өөрсдийн жижиг бизнесийг эхлэх анхны хөрөнгийг олж авах юм. “Ийм сургуулийг анх эхэлж байх үед манай сургуульд ямар ч ирээдүй байдаггүй байлаа. Ихэнх хүүхдүүд ачааны машины жолооч болно гэдэг байлаа. Гэтэл одоо багш, агрономч, инженер, фермер болно гэж мөрөөдөх боллоо” гэж сургуулийн багш хэлж байна.



Хот суурин газрын хүнсний аюулгүй байдал

Дэлхийн хүн амын ихэнх нь хот суурин газарт болон түүнийг тойрон амьдарч байна. Олон хүмүүс дүрвэгсдийн хуаран болон бусад орон гэр ариун цэврийн нөхцлөөр муу газар амьдарч байна. Маш олон хүмүүс ажлын байргүй, цэвэр ус, эрүүл хүнсээр дутагдаж байна. Хотод өөрийн гэсэн орон гэртэй, ажилтай, мөнгөтэй хүмүүст хүнсний аюулгүй байдал хурц асуудал биш. Яагаад гэвэл, тэд сайн чанарын хоол худалдаж авч чадна. Худалдаж авсан бүтээгдэхүүнээ зөв хадгалан, тэр ч байтугай өөрсдийн хоолыг хотын цэцэрлэгт тарих бололцоотой байдаг.


Ардын хүнсний дэлгүүр

Америкийн нэгдсэн улсын олон хотуудын нэгэн адил баруун Оакландад архи дарс, жанк хоолны худалдаа эрүүл шинэ хоолны худалдаанаас хамаагүй их байдаг. Архидан согтуурах асуудал, мансууруулах бодисын хэрэглээ болон хүчирхийллийн асуудал энэ хотыг амьдрахад аюултай газар болгодог. Баруун Оакландад амьдардаг дөрвөн хүн тутмын нэг нь хүнсний яаралтай тусламжийн хөтөлбөрөөс хамааралтай амьдарна.

Энэ асуудлыг олж харсан хүмүүс нийлж орон нутагтаа хүмүүсийн төлж чадах бага үнээр эрүүл хүнстэй болохын төлөө ажиллаж эхэлжээ. Эхлээд тэд ачааны машин авах мөнгө босгожээ. Тэд ачааны машинаа тод өнгөөр будаж, хүний анхаарал татах хөгжим зоож стерео системийг суурилуулсан байна. Долоо хоног бүр тэд хотын ойролцоох хөдөөний захад очиж, шинэ ногоо жимс худалдан авдаг байна. Тэгээд тэд хүн олноор цугларсан гудамжны үзүүрт машинаа зогсоогоод хөгжмөө тоглуулан шинэ хүнсний ногоогоо бага үнээр зардаг. Хүнсээ зарахдаа тэд эрүүл хүнсний ач холбогдлыг тайлбарлана. Тэд өөрсдийн явуулын дэлгүүрийг “Ардын дэлгүүр” гэж нэрлэсэн бөгөөд орон нутгийн иргэдийг ардын дэлгүүрт нэгдэхийг уриалдаг байна. Зарим хүмүүс ардын дэлгүүртэй нэгдэхээр болж өөрийн тарьсан ногоог ардын дэлгүүрт нийлүүлэхээр болжээ.

Залуу болон ахмадууд нэгдэж хоол хүнсийг яаж хийх талаар суралцжээ. Зарим хүмүүс өөрсдийн талбайг янзалж, ногоо тарьж эхлэв. Удсан ч үгүй ойролцоо сургууль болон орон нутгийн иргэдийн төв нь өөрийн гэсэн ногооны талбайг байгуулж эхэлжээ. Энэ бүх тариалангийн талбайнуудад ургуулсан ногоо, хүнсний бүтээгдэхүүнүүдийг ардын дэлгүүрийн ачааны машинд хүлээлгэж өгч худалддаг байна. Олон нийтийн дэмжлэгийг хүртэж, амжилтад хүрснийхээ дараа ардын дэлгүүр хотын захиргаанаас газар, мөнгө, сурталчилгаа хийж өгөх гэсэн гурван зүйл хүсчээ.

Засгийн газрын зарим нэг дэмжлэгтэйгээр тэд өөрсдийн төслөөр дамжуулан олон хүнийг хооллох болжээ. Ардын дэлгүүр нь одоо ч гэсэн баруун Оакландын хүн бүхэнд хямд үнээр эрүүл хоол хүнс өгөх системийг ажиллуулсаар байна. Хүмүүс зөвхөн ядуу гэдгээсээ болж муу хоол идэх ёсгүй. Тэдэнд эрүүл хоол идэх эрх бий гэж ардын дэлгүүрийнхэн уриалдаг байна. Тэд “Хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд хүнсний шударга ёсыг тогтоомоор байна” гэж хэлэх дуртай.



Хүнсний аюулгүй байдлыг хот газарт төлөвшүүлэхэд засгийн газрын тусламж хэрэгтэй

Ардын дэлгүүрийн туршлагаас үзэхэд хот газрын ядуу хорооллын хүмүүс хамтран ажиллаж өөрсдийн хүнсний аюулгүй байдлыг шийдвэрлэж болно гэдэг нь харагдаж байна. Тэдний эхлүүлсэн хөтөлбөр олон хүний амьдралд тусалсан юм. Гэхдээ энэ нь хүнсний асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүй юм.



- Баруун Оакландын хүмүүст яагаад эрүүл хоолнууд байгаагүй вэ?
- Ардын дэлгүүрийнхэн хүмүүсийн анхаарлыг эрүүл хүнсэнд яаж хандуулсан бэ?
- Орон нутгийн засаг захиргаа хэрхэн энэ төсөлд дэмжлэг үзүүлсэн бэ?
- Ардын дэлгүүрийнхэн төсөлдөө тусламж авахын тулд өөр ямар бүлэг байгууллагуудад хандаж болох вэ?
- Та хүнсний аюулгүй байдлыг орон нутагтаа дэмжихэд юугаар тусалж чадах вэ?

Хотуудын тогтвортой хүнсний бодлого

Удаан хугацаанд аюулгүй үргэлжлэх хүнс хоолтой байхын тулд хотын амьдрал болон хөгжлийн бүх асуудлыг бүх талаас нь хэлэлцэх ёстой. Тээвэр, боловсролын байгууллага, ажлын байр, шинэ орон сууц, барилгыг анх төлөвлөж байгаа хүмүүс хотод хоол ундаа хаанаас олж идэж байх ёстой вэ гэдгийг бодож олсон байх ёстой. Нийтийн цэцэрлэгт газар олгох, зах зээлүүдэд зориулсан тээвэр зохион байгуулах, хүнсний аюулгүй байдлын тухай хичээл заах, хоол тэжээлийн талаар сургуульд хичээл орох зэрэг нь орон нутгийн засаг захиргаа хүмүүсийнхээ өнөөдөр маргаашийн хүнсний аюулгүй байдлыг бий болгож, бэхжүүлэхэд хэрэглэх санаанууд юм.



Эсвэл:



Бага үнэтэй эрүүл хоол зардаг дэлгүүрүүд орон нутгийн эрүүл мэндийг дэмждэг.

Өлсгөлөнгийн нийгмийн болон улс төрийн шалтгаан

Газар үржил шимгүй болох, цаг агаар өөрчлөгдөх, усны олдоц хомсдох зэрэг олон шалтгаанаар өлсгөлөн ирж болно. Гэвч ихэнх орон нутагт өлсгөлөн нь ядуурлаас үүсдэг. Тариаланчдад газар олдохгүй үед, эсвэл хүмүүст хоол унд авах мөнгө олдохгүй бол хүмүүс өлсдөг. Нэг нутагт тохиолдож буй ядуурал өлсгөлөнгийн шалтгааныг ойлгохын тулд тухайн нутагт тулгарч байгаа хүн бүхэнд хамаарч буй хүнсний аюулгүй байдлын асуудлыг нягталж харах хэрэгтэй байдаг.



Корпорациудын хяналт хүнсний аюулгүй байдалд аюул учруулдаг

Хоол ундыг бүх хүнд хэрэгцээтэй, бүх хүний авах ёстой эрх гэж харахаас илүү нэгээс нөгөөд худалдаж болох жирийн нэгэн бараа хэмээн харах нь хүмүүсийг хооллохоос илүү ашиг олохын төлөөх тэмцэл рүү хазайлгаж, олон нийтийн эрүүл мэнд хохирдог. Ихэнх хүмүүс том компаниудын өмчийн том дэлгүүрүүдэд худалдаа хийж, хоол хүнсээ цуглуулдаг. Тэд том корпорациудын хийсэн бүтээгдэхүүнийг авч, том корпорациудын том газар ургуулсан тариа ногоог авч, том корпорациудын бэлтгэсэн бордоо химийн хорыг хэрэглэнэ.

Хүнсний аюулгүй байдлын бүх салбарт том корпорациудын хяналтад орох нь жижиг тариаланчдыг дампууруулж тэдний газрыг эзлүүлдэг. Корпорациуд хоол хүнс тариалахдаа тариалж байгаа газраасаа өөр газар борлуулж эхлэхэд орон нутгийн хүмүүс гаднаас орж ирсэн хоол ундыг хэрэглэж, заримдаа тэр үнэтэй хоол ундны үнэд ядарч цөхөрч эхэлдэг. Энэхүү хүнсний аюултай байдлаас үүссэн ашгаар корпорациуд ашиг олж амьдардаг бөгөөд бүхэл бүтэн улс орнууд болон дэлхийн хүнсний зах зээл тэднээс хамаарч эхэлдэг. Гэтэл энэ компанийн ажиллагаа доголдож эхлэнгүүт хүмүүс өлсгөлөнд нэрвэгддэг бөгөөд өөрсдийн дампуурч байгаа үйлдвэрийг юм уу, борлохгүй байгаа бүтээгдэхүүнээ засгийн газруудад худалдаж хүнсний тусламжид хэрэглүүлэх замаар корпорациудад ашигтай үлддэг. Хүмүүс хүнсний аюулгүй байдлаа өөрийн гарт аваагүй цагтаа байнга том компаниудын хяналтад байх болно.

Хуурайшилтай тэмцэхийн тулд алга болсон үрийг сэргээсэн нь

Нэгэн цагт Зимбабвегийн хүмүүс олон янзын үр тариа тарьдаг байжээ. 1960-аад оны ногоон хувьсгалын үеэр засгийн газар болон гадаадын агентлагууд тариаланчдад шинэ төрлийн үр, эрдэнэ шишүүдийг авчирч өгчээ. Тариаланчдад эрлийз эрдэнэ шиш таалагдсан байна. Яагаад гэвэл тэр том булцуутай хурдан ургадаг, борлуулахад хялбар байжээ. Засгийн газар ч тэднээс ургацыг нь худалдан авч дараа нь түүнийгээ Зимбабвегийн бусад хотууд болон гадаад орнуудад зардаг байлаа. Цаг хугацаа өнгөрөхөд Зимбабвечүүдийн гол хоол нь эрдэнэ шиш болж,

хүмүүс эрдэнэ шиш борлуулахын тулд олон газарт их хэмжээгээр тарих болжээ.

Гэтэл нэгэн зун ган болжээ. Зимбабвегийн тариалангийн талбайд маш бага бороо орж өмнөд Африк даяар ган болжээ. Эрдэнэ шиш муу ургаж идэх юм бага болов. Олонх өрхүүд өлсгөлөнгийн үеэр иднэ гэж эрдэнэ шиш хадгалсан боловч тэдний хадгалсан эрдэнэ шиш муудсан байжээ. Үүнд тариаланчид маш их гайхаж, урьд өмнө нь олон жилээр хадгалж болдог байсан шар будаа болон ичмээнээс өөр юм байна хэмээн гайхацгаажээ.

Хуурайшил дуусч бороо ороход аадар бороо хүчтэй үерлэн тарьсан тариа ногоог үндсээр нь булгалж, хуурай нутагт эрдэнэ мэт үнэтэй нимгэхэн хөрсийг нь угаан авч явжээ. Өлсгөлөн улам хүчтэй нэрвэж, Зимбабвегийн засгийн газар НҮБ-аас хүнсний тусламж гуйхаас өөр аргагүй болжээ. Том том хөлөг онгоц дүүрэн эрдэнэ шиш онгоцоор ирж өлсгөлөн хүмүүст тараагдаж байв. Гэвч хүнсний тусламжаар ирсэн эрдэнэ шиш болон шинэ эрлийз үрнүүд өлсгөлөн болон хүнсний аюулгүй байдлын удаан хугацааны асуудлыг шийдэж чадахгүй байлаа.

Тариаланчид “бороо нэмж оруулж чадахгүйгээс хойш бороогүй ч байсан сайн ургадаг аргаар тариалалтаа хийж аргаа өөрчилсө” гэж шийджээ. Тэд Зимбабве улсад урьд өмнө тарьдаг байсан жижиг үртэй шар будаа болон ичмээ будаануудаа эргэж тарья гэж цуглуулж эхэлжээ. Тариаланчид олж чадсан ургамал болгоныхоо үр бүрийг тарьж эхэллээ. Хуурайшлаас болж нэг төрлийн үр нь үхэхэд нөгөө төрлийн үр нь амьдарч үлддэг байв. Зарим тариаланчид ургацын дараа тариа ногооныхоо сүрлээр талбайгаа хучин үлдээж, өвс ногоог ялзмагтуулан өнгөний хөрсийг урсаж алга болохоос хамгаалж байв. Хойтон жил нь хөрс зөөлхөн хэвээр хадгалагдаж, тариа ногоо тарихад таатай болдог байлаа.

Зарим тариаланчид Лаб лаб хэмээх нэртэй вандуйг тариалж байв. Ингээд нэг улирлаас нөгөө улирал руу шилжихэд ямар нэгэн зүйл заавал ургасаар байлаа. Энэ вандуйгаар тэд малаа тэжээж, вандуйны иш навчнуудыг тайран хөрсөө хучиж, хөрсөө улам хамгаалж баяжуулж байлаа. Зимбабвед бороо бага орсон хэвээр байна. Гэхдээ тариаланчид дахин гадаадын тусламжаар ирсэн нутгийн биш үр тарихгүй гэж шийджээ. Тэд одоо өлсгөлөнгөөс урьдчилан сэргийлэх чадвартай болсон ба өөрсдийн орны хуурай хатуу уур амьсгалд зохицсон, хуурайшлыг тэсэн гарч чадах тариалалт хийх болжээ.




Ногоон хувьсгалын газар тариалангийн аргууд

1960- аад оны ногоон хувьсгал гарснаас хойш том корпораци болон гадаадын агентлагууд “сайжруулсан үрээр”, “бүх дэлхийг хооллоно” хэмээн зарлаж байлаа. Тэд химийн бордоо, шавж устгагч хэрэглэхийг ихэд дэмжиж байв. Тэд ногоон хувьсгалын нэрээр их хэмжээний газар авч, үр тарианы нөөцийг хянаж, хүнсний маркетинг борлуулалтын системийг хянаж байсан боловч дэлхий ертөнцийг өлсгөлөнгөөс аврах үүргээ биелүүлж чадаагүй юм. Харин ч дэлхий дээр гардаг өлсгөлөнгийн байдал дордсон юм.

Усны нөөцөд хүрэх бололцоогүй байдал

Үр тариа ургахын тулд ус шаардагддаг. Том компаниуд усыг их хэмжээгээр хэрэглэх тусам жижиг газартай жижиг тариаланчдад усны олдоч багасдаг. Ус бохирдох буюу усыг хувьчилж авахад ус уух эрх зөрчигдөж эхэлдэг. /6-р бүлгийг үз/ Газрын хөрсийг арчлах, менежмент хийх олон арга байдаг бөгөөд усны нөөцийг хамгаалангаа газар тариаланг усалж болдог. /9, 15-р бүлгийг үз/ Гэвч эдгээр арга замуудыг засгийн газар болон олон улсын агенлагууд хамгаалж дэмжих ёстой. Ингэснээр тэдний устай байх эрхийг хамгаалдаг юм.



Газрын алдагдал

Газрын ихэнх нь цөөхөн хүн юм уу, цөөхөн компаниудын нэр дээр очих нь хүнсний олон асуудлыг бий болгодог. Жижиг газартай тариаланчид газраа орхин нүүж, хот газарт очиж үйлдвэрт ажиллах, эсвэл том компаниудын газарт ажиллах хөлсний ажилчин болохоос өөр аргагүй болдог. Жижиг тариаланчид өөрийн гэсэн газаргүй, хоол тэжээл авах өөрийн гэсэн мөнгөгүй учраас өлсгөлөн ба хоол тэжээлийн дутагдалд ордог.

Ихэвчлэн том компаниуд ганцхан төрлийн их хэмжээний ургац авахын тулд цөөхөн хүн хөлсөлж, их хэмжээний химийн бодис, гирбацид ашиглан, тарьсан газраасаа өөр хол газар зарж борлуулдаг. Энэ нь хоол хүнсэнд олон төрлийн зүйл орох боломжгүй болгож, цөөхөн төрлийн тэжээл муутай хоол идэхэд хүрнэ. Мөн байгаль орчинд хор учруулж орон нутгийн хэмжээнд хүнсний хомсдолд оруулдаг. Энэ нь орон нутгийн соёлд муугаар нөлөөлж, хүмүүсийн газраа ашиглах явцдаа тогтоодог хамтач уур амьсгал, соёл арилж үгүй болдог.

Зах зээл болон зээллэгт хүрэх нөхцөл муудах

Газар тариалан нь цаг агаар болон зах зээлийн үнээс хамаарч байдаг учир тариаланчид ургац хураах хүртлээ мөнгө зээлж, заримдаа зах зээлийн нөхцөл байдал сайжрах хүртэл зээлээр амьдардаг. Банкнууд мөнгөө ихэвчлэн том хүчтэй

фермүүдэд зээлдэг учир жижиг газрын эздэд зээл олддоггүй. Энэ нь жижиг газартай тариаланчид болон гэр бүлд нь өлсөх аюулыг бий болгодог. Үүнээс болж олон тариаланчид газраа орхидог.

Нүүдэл

Газаргүй болж ядуурсан хүмүүс хоол хүнсийг яаж ургуулах талаар уламжилж ирсэн мэдлэгээ алдаж эхэлдэг. Хүүхдүүд газар дээр ажиллаж сурахаасаа өмнө хот газар явсан бол тэд хүүхдүүддээ газар тариалангийн мэдлэгийг өвлүүлэн үлдээж чаддаггүй. Хүмүүстэй хамт нүүж одсон гэр бүлийн мэдлэг, газрын тухай мэдлэг нь эргэж амархан сэргэхгүй алдагддаг юм.

Хурц халдварт өвчин

Хурц халдварт өвчин, ДОХ, сүрьеэ, хумхаа тархах үед олон сая хүмүүс дэлхий даяар нас барж, түүнийг дагаж өлсгөлөн болон хоол тэжээлийн дутагдал нэмэгдэнэ. Гэр бүлүүд болон орон нутгууд хурц халдварт өвчнөөс болж хамгийн идэвхтэй ажиллаж хөдөлмөрлөж байсан хамгийн их мэдлэг чадвартай хүмүүсээ алддаг. Тэр хүмүүстэй хамт хоол хүнсний үйлдвэрлэл алдагдаж байдаг. Хөдөө орон нутагт гарсан өвчний үр дагавар нь туршлагатай хүмүүс нас барж, хүнсний олдоц ховордоход хүргэдэг. Хүнс хоолны үйлдвэрлэл багассанаас бүхэл бүтэн орон нутгийн хүнсний аюулгүй байдал алдагддаг. Хүмүүсийг эрүүл байлгахын төлөө ажиллах нь хүмүүсийг хоолтой байлгахын төлөөх тэмцэл юм.

Мэдлэг дутагдах

Олон газруудад хүмүүс хоол ундыг хэрхэн үйлдвэрлэх талаар уламжлалт мэдлэгээ алдсан байдаг. Орчин нөхцөл гэнэт өөрчлөгдөж орон нутгийн хүмүүсийн тоо нэмэгдэх, газрын хөрс тэжээлгүй болж цаг агаар өөрчлөгдөх зэрэгт хуучин арга тохирохоо больж ирдэг. Хүмүүс хоол хүнсээ яаж үйлдвэрлэхээ мэдэхээ болиод ирэнгүүт үүний үр дагаварт өлсгөлөн, гачигдал нүүрлэдэг. Мөн хүнсний аюулгүй байдал алдагдана. Үүнээс урьдчилан сэргийлэх нэг арга нь хоол хүнс үйлдвэрлэх нутгийн зан заншлыг тариаланчдын сургууль, дунд сургууль, дадлагын сургууль, хөдөө аж ахуйн үйлчилгээ гэх аянуудаар залуу үедээ сургаж байх арга юм /322-р хуудсыг үз/.



Хоол хүнсгүйгээс өлсгөлөнд нэрвэгдэнэ.
Хоол хүнсний гачигдал нь шударга ёсны гачигдлаас ихэвчлэн үүсдэг.

Хоол хүнсний бие даасан байдал нь хүний эрх юм

Хүн бүхэн аюулгүй, эрүүл, соёлын хувьд зөвшөөрөгдсөн хоол хүнстэй байх эрхтэй. Хоол хүнсний бие даасан байдал нь өөрийн хүнсний системийг тодорхойлох, өөрийн орон нутгийн хүнсний аюулгүй байдлыг хангах эрх юм.

ВИАКАМПАСИНА хоол хүнсэн дээр ард түмний хяналт ТОГТООХЫГ ДЭМЖИВ

Олон жижиг тариаланчид үр тариа, бүтээгдэхүүнээ шударга үнээр зарж орлого олж чаддаггүй. Үүний нэг шалтгаан нь олон улсын худалдааны дүрэм журам баян улсуудад үйлчилж, том газрын эздэд таатай нөхцөл олгодогт байдаг. Олон тохиолдолд фермерүүд шударга үнэ тогтоолгож чаддаггүй, тэр ч байтугай орон нутгийн зах дээр импортоор орж ирсэн бүтээгдэхүүн илүү хямдхан байдаг. Үүнээс болж нутгийн тариаланчид бүтээгдэхүүнээ гадаадын хямд үнэтэй бараатай адил үнээр зарж өлсгөлөн ядууралд нэрвэгдэнэ. Энэ асуудлыг эсэргүүцэж олон орны тариачид Виакампасина буюу тариаланчдын зам хөдөлгөөн байгуулахаар цугларчээ.

Виакампасинаг фермерүүдийн шударга үнэ тогтоолгох эрхийн төлөө, газраа хамгаалж усны нөөцөө алдагдуулахгүй байхын төлөө, мөн хоол хүнсийг хэрхэн үйлдвэрлэж борлуулах талаар эрх мэдлээ эдлэхийн төлөө, дуу хоолойгоо нийлүүлэхийн төлөө байгуулж олон тариаланчдыг нэгтгэжээ. Виакампасинагийн хувьд хүнсний аюулгүй байдал нь зөвхөн хүнсний бие даасан байдлаар хангагдана гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл, тариаланчид ямар хүнсний бүтээгдэхүүн тарих, хэр зэрэг ихийг борлуулах гэдгээ шийддэг. Харин хэрэглэгч нар юу хэрэглэх, хэнээс авахаа өөрсдөө шийддэг байх хэрэгтэй гэж виакампасина үздэг.

Зарим газар виакампасина нь улс төрчид болон корпорациудад шахалт үзүүлж, орон нутгийн байгууллага, эвсэл үйлдвэрчний эвлэлтэй хамтран ажилладаг. Зарим газар тэд газаргүй тариаланчдад хэрэглээгүй байгаа газруудыг сэргээж хэрэглэх эрх олж өгөхийн төлөө тэмцдэг. Тэд бас орон нутгийн хэмжээнд хоол хүнсгүй ядарч зовж байгаа хүмүүсийг хоол хүнсээр хангадаг орон нутгийн байгууллага байгуулахад нь тусалдаг.

2005 онд далайн ёроолд асар хүчтэй газар хөдөлж цунами болоход энэ аюулд олон тариаланчдын газар өртөж, загасчид олноороо нас барсан юм. Энэ үед виакампасина тусламж үзүүлсэн байна. Гэхдээ тэд тусламжийн хоол хүнс материалуудыг гаднаас авчирч биш харин орон нутгийн байгууллагуудаас хоол хүнс худалдаж авах, жижиг гар урчуудаас багаж худалдаж авах, орон нутгийн жижиг үйлдвэрлэгч нараас материал худалдаж авах замаар тусламжийн бараануудаа цуглуулжээ. Тэд хүнсний тусламжийн чухал асуудлыг үүгээр хөндсөн юм. Хүнсний тусламж үзүүлж орон нутгийг ядуурал гачигдлаас хамгаалж аврахдаа гэр бүлүүдийг дэмжиж байна уу, эсвэл том компаниудыг дэмжиж байна уу, нутгаас нь авч байна уу, гаднаас оруулж байна уу гэдэг шинэ үнэлэмжийг тэд бий болгожээ.

Мөн өөрсдийн тусламжаар тэд орон нутгийн байгууллагуудыг хүчирхэгжүүлэхийг хамгийн түрүүнд анхаарчээ. Виакампасина өөрсдийн босгосон ихэнх мөнгөө удаан хугацаанд ашиглах, сэргээн засварлах ажилд зарцуулжээ. Жишээлбэл: орон гэр босгох, загасчны завь хийлгэх, загасчин болон тариаланчдад шинэ багаж хийх, тариалангийн газрыг тариалалтад зориулан сэргээх зэрэг ажлуудыг хийсэн байна. Байгалийн гамшгийн хохирогчдод туслах үедээ Вакампасина нь зөвхөн богино хугацааны тусламж үзүүлээд зогсохгүй удаан хугацааны хүнсний бие даасан байдалд нь хөрөнгө оруулалт хийжээ.